



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/103

Мандалговь

Г Ахмадад ээлтэй байгууллага шалгаруулах
Тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.11 дэх заалт, Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын "Журам шинэчлэн батлах тухай" 2017 оны А/493 дугаар захирамж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Ахмадад ээлтэй байгууллага"-ын шалгуур үзүүлэлтийг хангасан аймгийн ЗДТГ, Улсын тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийг 2017 оны "Ахмадад ээлтэй байгууллага"-аар шалгаруулж тус бүрийг 200000 /Хоёр зуун мянга/ төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шагналд шаардагдах 400000 /Дөрвөн зуун мянга/ төгрөг, өргөмжлөлийн 80000 /Наян мянга/ төгрөг, нийт 480000 /Дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

0200318